



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/445

Малгаалговь

"Хоггүй Дундговь" аян зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн орчны болон агаарын бохирдлыг арилгах, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн өнгө үзэмжийг сайжруулах, хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, цэвэр орчин бүрдүүлэх зорилго бүхий "Хоггүй Дундговь" аяныг 2018 оны 10 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулахыг сумдын Засаг даргын Тамгын газар, түүний дэргэдэх хэлтэс, агентлаг, албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. "Хоггүй Дундговь" аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. "Хоггүй Дундговь" аяны удирдамжийг мөрдлөг болгон орон сууц, гэр хорооллын айл өрх, хур хог ихээр үүссэн газар, гудамж, гуу, жалга болон албан байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх үйл ажиллагаанд менежментийн оновчтой шийдэл нэвтрүүлж үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авч тодорхой ажил зохион байгуулж Дундговь аймгийн нутаг дэвсгэрт хоггүй цэвэр орчин бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Бат-Орших)-д даалгасугай.

Дөрөв. "Хоггүй Дундговь" аяны явц үр дүнд тогтмол хяналт тавьж хангалтгүй ажилласан хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга, холбогдох байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллахыг Аймгийн засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010395

Аймгийн засаг даргын 2018 оны 10
дугаар сарын 11-ны өдрийн А/Н/С.

захирамжийн
нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ажлын хэсгийн ахлагч: Эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэнд, нөлөөллийн
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

- Сумдын засаг дарга нар
- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
- Хот тохижилтын албаны дарга
- Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын
улсын байцаагч
- Байгаль орчин аялал жуулчлалын газрын хүрээлэн буй
орчны бохирдол, байгаль орчны үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн
- Сумдын Засаг даргын тамгын газрын байгаль орчны
байцаагч, байгаль орчны ажилтан

Аймгийн засаг даргын 2018 оны 10
дугаар сарын 11-ны өдрийн 1445
захирамжийн
хоёрдугаар хавсралт

**"ХОГГҮЙ ДУНДГОВЬ" АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ**

Үндэслэл: "Хог хаягдлын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт (иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, орчны хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох), 9.4 дэх заалт, (сумдын засаг дарга нар нутаг дэвсгэрт хамаарах орон нутгийн чанартай авто замын байгууламж болон авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх үүрэгтэй) Аймгийн засаг даргын 01 дүгээр захирамжаар батлагдсан "Эрүүл мэндийг дэмжих жил"-ийн төлөвлөгөөний 3.1.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэв.

Зорилго: Дундговь аймгийн иргэдийн эрүүл ая тухтай ажиллах, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр өөрсдийн гадна орчны хогийг цэвэрлэх, сумын төвийн хог хаягдал ихээр үүссэн цэгүүд, далан, гуу жалга зэргийн хогийг цэвэрлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулна. Цаашид сар бүрийн сүүлийн 7 хоног бүр цэвэрлэж байх.

Зохион байгуулах байгууллага: Эрүүл мэндийн газар, Дундговь аймгийн хот тохижуулах газар ОНӨААТҮГ газар

Хамрагдах хүрээ: 15 сум

Хамтран ажиллах байгууллага:

Аймаг, сумдын засаг даргын тамгын газар, түүний харъяа хэлтэс агентлагууд, Дундговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Аймаг, сумын төвийн хог хаягдал ихээр үүссэн цэгүүд, далан, гуу жалга зэргийн хогийг цэвэрлэх
- Байгууллагаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын уут саванд түр хадгалах байдлаар хог тээвэрлэгч компанид хүлээлгэн өгч хэвшсэн байх
- Байгууллагын дотор болон гадна талбайд стандартын шаардлага хангасан хогийн савыг байршуулж тогтмол сулласан байх
- Байгууллагын гадна орчныхоо 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн хогийг тогтмол цэвэрлэх, орчныг бохирдолгүй цэвэр байлгаж, шарилж хогийн ургамлыг түүж цэвэрлэж хэвших
- Байгууллагын гадна орчныг тохижуулсан байх /шинээр тохижилт хийх, эсвэл сэргээн засварласан байх/